



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 4/21

Улаанбаатар хот

Ерөнхий эргүүл ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалт, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.2 дахь заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангуулах зорилгоор “Үзэсгэлэн болгогч” хэмээх XVII жарны харагчин туулай жилийн сар шинийн баярын хоногуудад буюу 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 20:00 цагаас 02 дугаар сарын 24-ний өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд Ерөнхий эргүүлийг томилон ажиллуулсугай.

2. Ерөнхий эргүүлийн ажиллах хуваарийг нэгдүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангуулж, ажлын байрны дэг журам, сахилга батыг сулруулахгүй байх зорилгоор 2023 оны 02 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт тавих Ерөнхий эргүүлийг автомашинаар хангахыг Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д үүрэг болгосугай.

4. Үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих зорилгоор орон нутгийн нисэх буудлууд болон зайлшгүй шаардлагатай салбар, нэгжүүдэд хариуцлагатай жижүүр томилох, Ерөнхий эргүүлийг нөхөж ажиллах нэгээс доошгүй албан тушаалтныг нөөцөд бэлэн байлгахыг Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д даалгасугай.

5.Батлагдсан хуваарийн дагуу сар шинийн баярын өдрүүдэд ажилласан ажилтнуудыг нөхөн амраахыг харьяа салбар, нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.


6.Ерөнхий эргүүлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Зам, тээврийн хөгжлийн яам болон Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлагыг тухай бүр шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА


Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2023 оны 11-р дугаар сарын 17-ны
өдрийн 11-р дугаар тушаалын
1-р дугаар хавсралт



ЕРӨНХИЙ ЭРГҮҮЛИЙН АЖИЛЛАХ ХУВААРЬ

Д/д	Нэр / Албан тушаал	Хугацаа	Утас
1	Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны дарга Б.Амартүвшин	II/20-20 ⁰⁰ -аас II/21-08 ⁰⁰ хүртэл	99087077, 71283101
2	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны дарга Б.Төгсөө	II/21-08 ⁰⁰ -аас II/21-20 ⁰⁰ хүртэл	95953198, 71283131
3	Нисэхийн сургалтын төвийн захирал Б.Урантөгс	II/21-20 ⁰⁰ -аас II/22-08 ⁰⁰ хүртэл	99091824, 71283115
4	Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газрын Төсөл хөтөлбөрийн хэлтсийн дарга Д.Одгэрэл	II/22-08 ⁰⁰ -аас II/22-20 ⁰⁰ хүртэл	99992060, 71282222
5	Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газрын Агаарын харилцааны тасгийн дарга Д.Түвшинбаяр	II/22-20 ⁰⁰ -аас II/23-08 ⁰⁰ хүртэл	94006655, 71282209
6	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дэд дарга Г.Амарцэцэг	II/23-08 ⁰⁰ -аас II/23-20 ⁰⁰ хүртэл	99097879, 71282016
7	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Нислэгийн стандарт, үйл ажиллагааны хяналтын хэлтсийн дарга Б.Билгүүдэй	II/23-20 ⁰⁰ -аас II/24-08 ⁰⁰ хүртэл	99193266, 71282240

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 17-ны
өдрийн 1/1 дугаар тушаалын
12 дугаар хавсралт



ЕРӨНХИЙ ЭРГҮҮЛИЙН АЖЛЫН УДИРДАМЖ

Ерөнхий эргүүл нь Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар, нэгжүүдийн уялдаа холбоо, нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангуулах, нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд хяналт тавих, мэдээ, мэдээллийг шуурхай дамжуулах, доголдол гарсан үед яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг удирдлагад танилцуулж, шийдвэр гаргуулах үүрэгтэйгээр дараах удирдамжийн дагуу ажиллана.

1.Ерөнхий эргүүл нь Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга болон Иргэний нисэхийн үндэсний төвийн даргад ээлж хүлээн авах, хүлээлгэн өгөх үед үйлдвэрлэлийн үйл ажиллагааны мэдээг 2 цаг тутам утсаар болон цахим (мессэж, вайбер)-аар өгөх ба чухал шаардлагатай тохиолдолд цаг харгалзахгүй өгөх;

2.Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар, нэгжийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, хүн, тээврийн болон технологийн автомашинуудын техникийн бэлэн байдал, найдвартай ажиллагааг хангуулах, өдөр тутмын үзлэг шалгалтын хяналтыг сайжруулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд саатал, доголдол гаргахгүй байхад хяналт тавих;

3.Ерөнхий эргүүл нь байгалийн гамшиг, гэнэтийн осол болон салбарын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх асуудал гарвал Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга болон холбогдох салбар, нэгжийн удирдлагад шуурхай мэдээлж, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч ажиллах;

4.Объектуудын цахилгааны болон галын аюулгүй байдал хангагдсан эсэх, гамшиг ослын үед ажиллах төлөвлөгөөний хэрэгжилт, хөдөлмөр хамгааллын зааварчилгаа, эрүүл ахуйн нөхцөл хангаж байгаа эсэхэд хяналт тавих;

5.Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар, нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих;

6.Иргэний нисэхийн ерөнхий газраас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, харьяа салбар, нэгжийн хариуцлагатай жижүүрт чиглэл өгч, шаардлага тавьж ажиллах;

7.Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар, нэгжүүдээс ирүүлсэн зөрчил, дутагдал, гарч болзошгүй аливаа нөхцөл байдал бий болсон болон энэ талаар харьяа байгууллагын удирдлага, ажилтнуудаас гарсан санал, мэдээллийг хүлээн авч, нэг бүрчлэн цаг хугацаа, мэдээлсэн эзэнтэй нь тодорхой тэмдэглэж, бүртгэлийг "Ерөнхий эргүүлийн дэвтэр"-т хөтлөх бөгөөд холбогдох удирдлагад мэдэгдэх, урьдчилан сэргийлэх талаар идэвхи санаачилгатай ажиллах;

8.Ерөнхий эргүүл нь ажиллах хугацаандаа харилцах утсаа нээлттэй бэлэн байлгаж, нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд салбар, нэгжүүдийн байр, агаарын тээвэрлэгч компаниудын ангар, агаарын хөлөг, объектоор явж үзлэг, шалгалт хийж, үйлдвэрлэлийн хэвийн, найдвартай ажиллагаанд хяналт тавьж ажиллах;

9.Ерөнхий эргүүл нь салбар, нэгжүүдээс томилогдсон хариуцлагатай жижүүрээс мэдээллийг 2 цаг тутам авч "Ерөнхий эргүүлийн дэвтэр"-т дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөн, шаардлагатай мэдээлэл, баримтыг хавсаргах бөгөөд "Ерөнхий эргүүлийн дэвтэр", үнэмлэхийг дараагийн ээлжийн эргүүлд биечлэн хүлээлгэн өгнө.

Чухал шаардлагатай үед холбоо барих утасны жагсаалт

№	Холбогдох байгууллага / албан тушаалтан	Утас
1	ИНЕГ-ын дарга	99113244, 71282001
2	ИНҮТ-ийн дарга	88089002, 71285000
3	НААХЗА-ны шуурхай мэдээлэл	98985525
4	ГТҮШХА-ны диспетчер	71284016
5	"Буянт-Ухаа" ОУНБ-ын ерөнхий зохицуулагч	71283047
6	ХНАА-ны ерөнхий зохицуулагч инженер	71281604
7	Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтсийн жижүүр	98220762, 71283061
8	ЗТХЯ-ны хариуцлагатай жижүүрийн утас	51-263179
9	Нийслэлийн онцгой байдлын газрын харьяа Мэдээлэл, шуурхай удирдлагын төв	105, 70191013, 261763, 261761
10	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн төв диспетчер	343004, 343048
11	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн баруун түгээх төв	70141073, 70047004
12	Нисэхийн ус суваг	70049707